

“МОНГОЛ КООСЭН” ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖИЙН ОЮУТНЫ ДҮРЭМ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. “Монгол Коосэн” Технологийн коллежийн (цаашид “Сургууль” гэх) оюутны дүрмийн зорилго нь оюутныг хичээл сурлагадаа хариуцлагатай хандаж, бие даан сурах чадварыг хөгжүүлэх, аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх, оюутны эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Оюутан нь шинжлэх ухааны мэдлэг, мэргэжлийн ур чадвартай, хууль шударга ёсыг дээдэлдэг, хүнлэг иргэн болохын төлөө хичээнгүйлэн суралцана.
- 1.3. Энэхүү дүрмийг тус сургуульд суралцаж байгаа оюутан бүр дагаж мөрдөнө.
- 1.4. Оюутны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Захирлын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцэж, захирлын тушаалаар баталгаажуулна.

Хоёр. Оюутны эрх, үүрэг

2.1. Оюутан дараах эрхтэй:

- 2.1.1. Суралцах нөхцөл бололцоогоор хангуулах;
- 2.1.2. Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу суралцах;
- 2.1.3. Хичээлээс гадуурх секц, сонгон, дугуйлан, клуб болон сургуулиас зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, цагийн хуваариа зохицуулан хамрагдах;
- 2.1.4. Оюутан нь эрдэм шинжилгээ, судалгааны ажил болон мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх тэмцээн, уралдаанд идэвхтэй оролцох;
- 2.1.5. Сургалтын төлбөр, хандивын зарцуулалтын талаар мэдээлэл авах;
- 2.1.6. Сургууль, багшийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар санал гомдол гаргах, шаардлага тавих, мэдээлэл авах;
- 2.1.7. Хууль тогтоомжид заасны дагуу тэтгэлэг, тусламж авах, хөнгөлөлт эдлэх;
- 2.1.8. Оюутан болон түүний эцэг эх, асран хамгаалагч хүсэлт гаргасан тохиолдолд жилийн чөлөө авах;
- 2.1.9. Оюутны эцэг эх, асран хамгаалагч улирлын чөлөө авах хүсэлт гаргасан тохиолдолд сургалтын албаар шийдвэрлүүлэх;
- 2.1.10. Оюутан мэргэжлийнхээ дагуу эрхлэх ажлаа хөдөлмөрийн зах зээл дээр сонгох;
- 2.1.11. Сургуулийн Удирдах зөвлөлд төлөөлөлтэй байх.

2.2. Оюутан дараах үүрэгтэй:

- 2.2.1. Сургалтын хөтөлбөрийн агуулгыг хугацаанд нь бүрэн эзэмших;
- 2.2.2. Багш, ажилтны тавьсан шаардлага, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх;
- 2.2.3. Бие дааж суралцах арга барилыг эзэмших;
- 2.2.4. Багш, шавийн харилцааг хүндэтгэн дээдлэх;
- 2.2.5. Сургуулийн оюутны дүрэм, оюутны ёс зүйн дүрмийг сахин биелүүлэх;
- 2.2.6. Хичээлийн цагийг баримтлан, үр бүтээлтэй ашиглах;
- 2.2.7. Хичээлээс хоцрохгүй, хичээл таслахгүй байх;
- 2.2.8. Сургуулийн өмч хөрөнгө, эд хогшил, сургалтын хэрэглэгдэхүүн, ном сурах бичиг, гарын авлагыг ариг гамтай хэрэглэх;
- 2.2.9. Завсарлагаанаар хичээлээс хоцорч орох, хичээлийн үеэр ангиас гарах тохиолдолд хичээл зааж буй багшаас зөвшөөрөл авах;
- 2.2.10. Сургалтын төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөх;

- 2.2.11. Дадлагын хичээлд суухдаа зайлшгүй зориулалтын дадлагын хувцас өмсөж, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах;
- 2.2.12. Сургуулийн хүрээнд улс төр, шашинтай холбоотой ухуулга, сурталчилгаа зохион байгуулахгүй байх;
- 2.2.13. Сургуулийн орчин болон олон нийтийн газар биеэ зөв боловсон авч явах, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг сахин биелүүлэх.
- 2.2.14. Олон нийтийн хэв журмыг зөрчихгүй байх, элдэв зөрчил, гэмт хэрэгт холбогдохгүй байх;
- 2.2.15. Оюутан цахим орчинд бусадтай зөв боловсон, хүндэтгэлтэй харьцаж, ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэх.

Гурав. Сургууль болон олон нийтийн газар баримтлах дэг

3.1. Ерөнхий зүйл

- 3.1.1. Хариуцлагатай, сахилга баттай, үнэнч шударга байх;
- 3.1.2. Багш, ажилтан, эцэг эх, зочидтой мэндэлдэг байх;
- 3.1.3. Сургуулийн анги танхимд, коридорт биеэ зөв боловсон авч явах;
- 3.1.4. Сургуулийн болон олон нийтийн өмч хөрөнгөд ариг гамтай хандах;
- 3.1.5. Бусдын эд зүйлийг зөвшөөрөлгүй авахгүй байх;
- 3.1.6. Сургуульд үнэтэй эд зүйл авчрахгүй ба алдсан тохиолдолд сургууль хариуцахгүй;
- 3.1.7. Сургуулийн орчинд согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх, тамхи татахыг хориглоно;
- 3.1.8. Сургуулийн орчинд бусдыг дээрэлхэх, гадуурхах, хэрүүл маргаан хийх, зодолдох зэрэг үйлдлийг хориглоно;
- 3.1.9. Дараах эд зүйлийг сургуульд авчрахыг хориглоно. Үүнд:
 - Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис
 - Шатамхай болон тэсэрч дэлбэрэх бодис
 - Хурц иртэй зүйл, хутга, зэвсэг
 - Үнэт эдлэл

3.2. Цаг ашиглалт

- 3.2.1. Оюутан хичээлээс чөлөө авах зайлшгүй тохиолдолд оюутны албанд хандаж чөлөөний хуудас авах ба оюутны алба нь эцэг эх, асран хамгаалагчид мэдэгдсэний үндсэн дээр чөлөө олгоно. 7 хоногоос дээш өдрийн чөлөөг Сургалтын албатай зөвшилцсэний үндсэн дээр олгоно.
- 3.2.2. Хичээл эхлэхээс 10 минутын өмнө ирж, хичээлийн бэлтгэлээ хангах.
- 3.2.3. Хичээлийн бус цагаар сургууль дээр зохион байгуулах үйл ажиллагаанд оролцох оюутнууд оюутны албанд бичгээр хүсэлт гаргаж, зөвшөөрөл авна.
- 3.2.4. Хичээлээс хоцорсон тохиолдолд Оюутны албанд мэдэгдэж, хоцорсон цагаа тэмдэглүүлэн, хичээлд суух зөвшөөрлийн хуудас авна. Зөвшөөрлийн хуудас авсан тохиолдолд хичээлийн ирцийг хоцорсноор бүртгэнэ.
- 3.2.5. Тухайн улиралд суух цагийн 25 хүртэлх хувийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тасалсан болон хичээлээс хоцорсон тохиолдолд сануулах арга хэмжээ авна.

3.3. Шалгалт, диплом хамгаалалт

- 3.3.1 Шалгалт, диплом хамгаалалт эхлэхээс 10 минутын өмнө ирж бэлтгэл хангах;
- 3.3.2 Хуулах, хуулуулах үйлдэл гаргавал шалгалтын материалыг хүчингүйд тооцох;
- 3.3.3 Гар утас болон сурах бичиг, дэвтэр ашиглахгүй байх;
- 3.3.4 Шалгалтын дундуур хүнсний зүйл хэрэглэхгүй байх.

- 3.3.5 Оюутан тухайн хичээлийн улирлын дүнгээр 0-59 оноогоор дүгнүүлсэн бол дахин шалгалтад орно. Энэ тохиолдолд 1 багц цагийн төлбөрийг дахин шалгалтын өмнө төлсөн байна.
 - 3.3.6 Оюутан тухайн хичээлээр дахин шалгалтад 2 удаа орох эрхтэй.
 - 3.3.7 Тухайн хичээлийн жилд 3 хичээлээр дахин шалгалт өгсөн ч хангалтгүй дүн авсан тохиолдолд улируулан суралцуулна.
- 3.4. Анги, танхим, лаборатори, дадлагын газарт
- 3.4.1. Багштай босч мэндлэх;
 - 3.4.2. Хичээл сургалтад санаачилгатай оролцох;
 - 3.4.3. Ангид малгай, гадуур хувцастай суухгүй байх;
 - 3.4.4. Дадлагын хичээлд дадлагын хувцас өмсөх;
 - 3.4.5. Хичээлийн бэлтгэлийг бүрэн хангаж ирэх;
 - 3.4.6. Оюутан нь багшийн шаардлага, өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлж, багш шавийн харилцааг эрхэмлэх;
 - 3.4.7. Анги, танхимд хүнсний зүйл хэрэглэхгүй байх;
 - 3.4.8. Анги танхим, сургуулийн орчинд хог хаяхгүй байх;
 - 3.4.9. Хичээлд оролцохдоо гар утас болон цахим төхөөрөмжөө унтраах, цэнэглэхгүй байх.
 - 3.4.10. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааг мөрдөх.
- 3.5 Шүүгээний хэрэглээ
- 3.5.1. Чийгтэй, нойтон хувцас орхихгүй байх;
 - 3.5.2. Хүнсний болон шингэн зүйл орхихгүй байх;
 - 3.5.3. Эмх цэгцтэй, хаягтай байх;
 - 3.5.4. Өөрийн буруугаас түлхүүр гээж, цоож эвдсэн тохиолдолд төлбөрийг тухайн оюутан хариуцаж, төлнө;
 - 3.5.5. Хичээлийн жил дуусах болон сургуулиас чөлөөлөгдөх үед шүүгээний түлхүүрийг оюутны албанд хүлээлгэн өгнө;
 - 3.5.6 Шүүгээнд байгаа эд зүйлээ өөрийн хариуцлагагүйгээс болж алдсан тохиолдолд сургууль хариуцахгүй бөгөөд хуулийн байгууллагад хандаж болно.

Дөрөв. Сургалтын төлбөрийн талаар

- 4.1. Оюутан өөрийн хүсэлтээр сургуулиас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан тохиолдолд сургалтын төлбөрийн зөрүүг буцаан олгоно.
- 4.2. Хангалтгүй суралцсан, мөн сахилгын зөрчлийн улмаас сургуулиас хасагдсан, хүндэтгэх шалтгаангүйгээр сургуулийг орхисон тохиолдолд хичээлд суусан хугацааны төлбөрийг суутгаж тооцно.
- 4.3. Оюутан сургалтын төлбөрийг 2 хуваан төлж болно.
- 4.4. Өөр сургуулиас шилжиж ирсэн оюутан өмнө суралцсан хичээлийн кредитийг тооцуулан сургалтын төлбөр төлнө.

Тав. Хүлээх хариуцлага

- 5.1. Дараах зөрчил гаргасан тохиолдолд сануулах, улируулан суралцуулах, шаардлагатай тохиолдолд сургуулиас чөлөөлөх хүртэл арга хэмжээ авна.

5.1.1. *Дараах тохиолдолд сануулах арга хэмжээ авна. Үүнд:*

- 5.1.1.1 Хичээл болон хичээлээс гадуурх үйл ажиллагааг санаатайгаар үймүүлж, тасалдуулах;
- 5.1.1.2 Багш, ажилтан, оюутан, эцэг эхтэй хүндэтгэлгүй харьцах;
- 5.1.1.3 Сургуулийн орчинд бооцоот тоглоом тоглох;
- 5.1.1.4 Бусдын эд зүйлийг зөвшөөрөлгүй авах;
- 5.1.1.5 Сургуулийн орчинд тамхи хэрэглэх;
- 5.1.1.6 Хичээл дундуур гар утас, цахим төхөөрөмжийг ашиглаж, багшийн шаардлагыг биелүүлээгүй;
- 5.1.1.7 Хэрүүл маргаан өдөөх, бусдыг дээрэлхэх, доромжлох;
- 5.1.1.8 Сургууль дээр дүрмийн 3.1.9 дэх хэсэгт заасан зүйлсийг авчрах;
- 5.1.1.9 Оюутан солилцооны хөтөлбөрт хамрагдах хугацаанд сургуулийн болон эх орны нэр хүндэд сөргөөр нөлөөлөх үйл ажиллагаанд оролцох, үйлдэл гаргах.

5.1.2. *Дараах тохиолдолд улируулан суралцуулах арга хэмжээ авна. Үүнд:*

- 5.1.2.1. Дүрмийн 3.3.7 дахь хэсэгт заасны дагуу курс улируулан суралцуулах.

5.1.3. *Дараах тохиолдолд сургуулиас чөлөөлөх арга хэмжээ авна. Үүнд:*

- 5.1.3.1. Согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх;
- 5.1.3.2. Гэмт хэрэгт холбогдох, хулгай дээрэм, зодоон зохион байгуулах, зодоон хийх;
- 5.1.3.3. Дүрмийн 5.1.1 дэх хэсэгт заасан зөрчлийг давтан гаргаж, 2 удаа бичгээр сануулах арга хэмжээ авагдсан бол;
- 5.1.3.4. Тухайн хичээлийн жилд суух цагийн 50% болон түүнээс дээш хувьд нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тасалсан тохиолдолд сургуулиас чөлөөлөх.

5.1.4. *Бусад*

- 5.1.4.1 Оюутан солилцооны хөтөлбөр, гадаад улсад хийх үйлдвэрлэлийн дадлага, бусад уралдаан, тэмцээнд оролцохыг хориглоно;
- 5.1.4.1. Хичээлд суухыг тодорхой хугацаагаар хориглох, хичээлийн цагийг тасалсанд тооцох;
- 5.1.4.2. Нийгэмд болон сургуульд тустай ажил хийлгэх.
- 5.1.5. Учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх.

5.4 Оюутны зөрчлийн асуудлыг сургуулийн Ёс зүйн зөвлөлийн хурлаар хэлэлцэж, гаргасан санал, дүгнэлтэд үндэслэн “Монгол Коосэн” технологийн коллежийн Хөдөлмөрийн дотоод журам, Оюутны дүрмийн 5-р зүйлийн 5.1.1, 5.1.2, 5.1.3, 5.1.4 дэх хэсэг, Оюутны ёс зүйн дүрмийн 4-р зүйлийн дагуу Захирлын дэргэдэх зөвлөл шийдвэр гаргах ба шийдвэрийг захирлын тушаалаар баталгаажуулж, эцэг эх, асран хамгаалагч, багш ажилтан, оюутанд тус тус мэдэгдэнэ.

-00o00-